



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 805

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ┐
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 12 нэрийн, нийт 7,306,679.00 (долоон сая гурван зуун зургаан мянга зургаан зуун далан ес) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Б.Ганзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах, сэлбэн ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 30 ны/ний өдрийн
805 дугаар тогтоолын хавсралт

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бүрийн балансын үнэ /төгрөг/	Нийт балансын үнэ /төгрөг/
1	Тоос сорогч	9/28/2018	1	269,990.00	269,990.00
2	Суурин утас	5/31/2019	3	65,000.00	195,000.00
3	Индүү	2/28/2019	1	87,999.00	87,999.00
4	Индүү	6/30/2019	1	129,990.00	129,990.00
5	Зургийн аппарат	12/31/2019	2	289,300.00	578,600.00
6	Зургийн аппарат	4/4/2019	1	301,300.00	301,300.00
7	Сандал	11/20/2013	8	46,200.00	369,600.00
8	Сандал	5/28/2014	31	40,000.00	1,240,000.00
9	Сандал	4/23/2018	18	169,900.00	3,058,200.00
10	Сандал	10/30/2018	10	72,000.00	720,000.00
11	Сандал	11/30/2019	4	60,000.00	240,000.00
12	Лабораторын сандал	4/29/2013	2	58,000.00	116,000.00
Нийт дүн			82		7,306,679.00
					(долоон сая гурван зуун зургаан мянга зургаан зуун далан ес)